



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Дашбалбар хөгжил” ОНӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2026/002/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn

Дорнод аймаг

2026 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Нармандах

Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК

Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг

Утас: 88883776 Цахим хаяг:

khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5 Ерөнхий чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүн	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .	Error! Bookmark not defined.
4.5.1 Завсрын аудитын талаар.....	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	11

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4203

2025.03.13 № 353

танай _____-ны № _____-т

Г **Хязгаарлалттай дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дашбалбар хөгжил” ОНӨҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын бүх ажилчдад орон нутгийн нэмэгдэл нийт 33.492.7 мянган төгрөгийг олгосон, Байгууллагын өмнөх удирдлага шинээр томилогдон ажиллахдаа улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрийн нэрийг томилогдсоноос 14 хоногийн дотор солих хугацаанд өөрчлөлт хийгээгүйн улмаас 500,000 төгрөгийн торгууль оноосныг байгууллагын хөрөнгөөс шилжүүлсэн, Техник /ковш/ түрээсийн орлого байгууллагын харилцахад орж ирсэн боловч гэрээ байгуулаагүй, машин техникийн ашиглах хугацаа, хариуцан хүлээж авсан, хүлээлгэн өгсөн акт үйлдсэн тэмдэглэл, дэмжих баримтгүй, байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэл дэх 38,860.2 мянган төгрөгийн 60 квт дизель станц хөрөнгийг бусдад түрээсийн гэрээ байгуулан ашиглуулсан боловч бодитоор оршин байхгүй, хөрөнгийг буцаан авахтай холбоотой шүүхийн байгууллагад хандан өмгөөлөгчийн төлбөрт 1,500.0 мянган төгрөг төлсөн зэрэг нийт 603,636.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг түвшнээс давж, дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэл дэх 38,860.2 мянган төгрөгийн 60 квт дизель станц хөрөнгийг бусдад түрээсийн гэрээ байгуулан ашиглуулсан боловч биетээр оршин байхгүй, хөрөнгийг буцаан авахтай холбоотой шүүхийн байгууллагад хандан өмгөөлөгчийн төлбөрт 1,500.0 мянган төгрөг төлсөн.

- 2126050185

Аудитын гол асуудлууд

Тус байгууллага нь зорилтот түвшний гүйцэтгэлийн төлөвлөсөн, тайлант хугацаанд ашигтай ажиллах зорилт тавьдаггүй, төсөвт байгууллагатай адилаар төсөв баталдаг, өөрийн үйл ажиллагааны орлогыг 58,300.0 мянган төгрөгөөр төлөвлөн, гүйцэтгэлээр 61,353.7 мянган төгрөгийн орлого олж, орлогын төлөвлөгөөг 5.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын удирдлага нь жилийн төлөвлөгөөг төлөвлөж, гүйцэтгэлийг тайлагнаагүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэгжүүгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Хөрөнгө		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	10,602,221.00	817,152.13
1.1.2	Дансны авлага	300,000.00	344,391.00
1.1.6	Бараа материал	8,800,000.00	8,800,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	19,702,221.00	9,961,543.13
1.2.1	Үндсэн хөрөнгө	9,658,762,497.51	10,055,467,406.07
1.2.2	Биет бус хөрөнгө	1,632,000.14	1,200,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	9,687,061,163.65	10,083,334,072.07
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,706,763,384.65	10,093,295,615.20
2.1.1.2	Дансны өглөг		
2.1.1.3	Татварын өр	172,233.63	121,028.89
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	172,233.63	121,028.89
2.3	Өмч:		
2.3.1	төрийн		
2.3.2	хувийн		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Дахин үнэлгээний зөрүү	1,699,972.81	1,699,972.81
2.3.10	Хуримтлагдсан ашиг	9,704,891,178.21	10,091,474,613.50
2.3.11	Эздийн өмчийн дүн	9,706,591,151.02	10,093,174,586.31
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	9,706,763,384.65	10,093,275,615.20

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	170,592,232.85	357,742,938.00
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	170,592,232.85	357,742,938.00
4	Түрээсийн орлого	16,150,000.00	17,150,000.00
5	Хүүний орлого	29,108.52	12,488.83
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	232,000,000.00	811,909,721.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	647,575,173.97	777,477,361.92
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,500,000.00	1,450,350.00
12	Бусад зардал	6,700,600.00	21,372,000.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-

14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-135,905,585.78	-16,665.87
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-51,333.51
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)		-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-373,910,018.38	386,447,436.53
19	Орлогын татварын зардал	-	-
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-373,910,018.38	386,447,436.53
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-373,910,018.38	386,447,436.53
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Дахин үнэлгээний зөрүү	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,699,972.81	10,078,801,196.59	9,332,681,132.64
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	373,910,018.38	373,910,018.38
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,699,972.81	9,704,891,178.21	9,706,591,151.02
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-		
11	Залруулсан үлдэгдэл	-		
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-386,583,435.29	-386,583,435.29
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-		
17	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,699,972.81	10,091,474,613.50	10,093,174,586.31

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	186,771,341.37	374,959,540.36
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	186,771,341.37	374,959,540.36
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	940,032,864.35	673,373,108.41
1.2.1	Ажиллагчдад төлсөн	94,347,880.00	141,166,427.57
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	27,393,515.31	34,121,218.57
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	23,790,560.00	17,082,980.00
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	17,393,513.69	16,209,231.57
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	15,095,613.00	49,114,168.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	10,134,124.52	15,407,080.10
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	251,250.00	521,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	11,135,510.85	37,279,298.89
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3	Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү	-	-
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-12,770,626.00	-9,785,068.87
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	23,372,847.00	10,602,221.00
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,602,221.00	817,152.13

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	Зөрүү			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Татаас санхүүжилт	127,848,532.90	399,544,600.00	293,614,478.00	(105,930,122.00)	73.5
Үндсэн үйл ажиллагааны орлого	58,922,808.47	58,300,000.00	81,290,948.83	22,970,948.83	139.4
Бусад орлого	-	-	1,394,630,794.00	-	
НИЙТ ОРЛОГЫН ДҮН	186,771,341.37	457,844,600.00	1,186,815,147.83	(82,959,173.17)	259.2
Борлуулалт маркетингийн зардал	193,058,106.56	384,934,363.01	299,920,669.96	(85,013,693.05)	77.9
Ерөнхий удирдлагын зардал	2,500,000.00	2,300,000.00	1,450,350.00	(849,650.00)	63.1
Бусад зардал	6,700,600.00	14,576,680.00	21,372,000.00	6,795,320.00	146.6
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	-135,905,585.78	-	67,999.38	-	
Элэгдлийн зардал	494,328,238.97	-	477,420,693.20	477,420,693.20	
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	560,681,359.75	401,811,043.01	800,231,712.54	398,352,670.15	199.2
ТАТВАР	-	-	-	-	
ТАТВАРЫН ДАРААХ АШИГ	-373,910,018.38	56,033,556.99	386,583,435.29	-481,311,843.32	14.5

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 1,441,297.5 мянган төгрөгийн дараах 5 алдааг¹ аудитын явцад залруулав. Үүнд:

1. Наадмын талбай өргөтгөх шинэчлэх ажлын 457,994.3 мянган төгрөгийн хөрөнгийг дуусаагүй барилгад бүртгээгүй, УСНББОУС 1 "Санхүүгийн тайлагналын толилуулга", санхүүгийн тайлагналын "Үнэлгээ ба хуваарилалт", "Толилуулга" зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасны дагуу санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлан, эздийн өмчийн тайланд нэмж залруулав.
2. Үндсэн хөрөнгийн сайжруулалт дансанд 136,726.8 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэхдээ харьцсан дансыг буруу сонгосныг бусад орлогоор бүртгэснийг, УСНББОУС 1 "Санхүүгийн тайлагналын толилуулга", санхүүгийн тайлагналын "Үнэлгээ ба хуваарилалт", "Толилуулга" зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасны дагуу санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлан, эздийн өмчийн тайланд нэмж залруулав.
3. Өмнөх онд шилжиж ирсэн хөрөнгийн элэгдлийг бүртгэхдээ хойшлогдсон татварын хөрөнгө дансанд 26,666.7 мянган төгрөг бүртгэснийг өмнөх үеийн хуримтлагдсан үр дүн дансанд тусган, УСНББОУС 1 "Санхүүгийн тайлагналын толилуулга",

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

санхүүгийн тайлагналын “Үнэлгээ ба хуваарилалт”, “Толилуулга” зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасны дагуу санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлан, эздийн өмчийн тайланд нэмж залруулав.

4. Үнэ төлбөргүй хүлээн авсан 799,909.7 мянган төгрөгийн хөрөнгийн хойшлогдсон татварын өр буруу тусгасныг орлогын дэлгэрэнгүй тайлангийн бусад орлогоор бүртгэж, УСНББОУС 1 "Санхүүгийн тайлагналын толилуулга", санхүүгийн тайлагналын “Үнэлгээ ба хуваарилалт”, “Толилуулга” зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасны дагуу санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлан, эздийн өмчийн тайланд нэмж залруулав.
5. ОНХСангаас орж ирсэн 20,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг зөрүүтэй олгосноос зарцуулсан зардлыг орлогын дэлгэрэнгүй тайланд тусгаж, УСНББОУС 1 "Санхүүгийн тайлагналын толилуулга", санхүүгийн тайлагналын “Үнэлгээ ба хуваарилалт”, “Толилуулга” зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасны дагуу санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлан, эздийн өмчийн тайланд нэмж залруулав.

Мөн аудитаар нийт 603,636.1 мянган төгрөгийн зөрчил²-д 33,992.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 569,643.4 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 1 зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн санхүүгийн аудитын асуудлаарх зөрчил 76,039.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 70,673.7 мянган төгрөгөөр их тул Хязгаарлалттай дүгнэлт өгөв.

5.1 Төлбөрийн акт

1. Байгууллагын бүх ажилчдад орон нутгийн нэмэгдэл нийт 33.492.7 мянган төгрөгийг олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.17-д "Захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно", Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 2.1-д "Орон нутагт ажилласны нэмэгдлийг хөдөөгийн сум (тосгон)-д ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар... тус тус бодож, сар бүр олгоно" гэж заасантай тус тус нийцээгүй байна.
2. Байгууллагын өмнөх удирдлага шинээр томилогдон ажиллахдаа улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрийн нэрийг томилогдсоноос 14 хоногийн дотор солих хугацаанд өөрчлөлт хийгээгүйн улмаас 500,000 төгрөгийн торгууль оноосныг байгууллагын хөрөнгөөс шилжүүлсэн байгаа нь Хуулийн этгээдийн тухай хуулийн 13.4-д "Өргөдөл гаргагч шинээр болон өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдах хуулийн этгээдийг бүртгүүлэх өргөдлийг тухайн хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулснаас хойш 30 хоногийн дотор улсын бүртгэлийн байгууллагад гаргана", Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2 Албан шаардлага

1. Техник /ковш/ түрээсийн орлого байгууллагын харилцахад орж ирсэн боловч гэрээ байгуулаагүй, машин техникийн ашиглах хугацаа, хариуцан хүлээж авсан, хүлээлгэн өгсөн акт үйлдсэн тэмдэглэл, дэмжих баримтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэл дэх 38,860.2 мянган төгрөгийн 60 квт дизель станц хөрөнгийг бусдад түрээсийн гэрээ байгуулан ашиглуулсан боловч бодитоор оршин байхгүй, хөрөнгийг буцаан авахтай холбоотой шүүхийн байгууллагад хандан өмгөөлөгчийн төлбөрт 1,500.0 мянган төгрөг төлсөн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна", 30 дугаар зүйлийн 30.3-д "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй байна. Худалдан авалтын төлөвлөгөөнд харьцуулалтын аргаар шалгаруулах 40,109.1 мянган төгрөгийн урсгал зардлыг үнэлгээний хорооны тэмдэглэлд дахин тендер зарлахаар шийдвэрлэсэн боловч шууд худалдан авалт хийсэн, гүйцэтгэлээр 308,946.7 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаанд үнэлгээний хорооны гишүүдийн АЗ сертификат, ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдэл, үнэлгээний хороонд ажиллах зөвшөөрлийн мэдүүлэг, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд гарын үсэг зурж баталгаажуулаагүй.
3. Шилэн дансны 158 мэдээнээс 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 53,459.3 мянган төгрөгийн 2 гүйлгээ, зарлагын 42,293.2 мянган төгрөгийн зарлагын 5 гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай нийцэхгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Эзэмшигчийн өмчтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Байгууллагын гэрчилгээ дээрх өмчийн дүн, санхүүгийн тайлан дээрх өмчийн дүнгээс 431,843.9 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан

бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 болон 13.1 дэх заалтыг баримтлан, улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх дүн, санхүүгийн тайлан дахь өмчийн дүнг адил болгох.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Наадмын талбай өргөтгөх ажлын 457,994.3 мянган төгрөгийн хөрөнгийг дуусаагүй барилгад бүртгээгүй	1	457,994.3			1	194,700.0	1	194,700.0				
Өмнөх онд шилжиж ирсэн хөрөнгийн элэгдлийг бүртгэхдээ хойшлогдсон татварын хөрөнгө дансанд бүртгэснийг өмнөх үеийн хуримтлагдсан үр дүн дансанд тусган	1	461,9			1	461,9	1	461,9				
Үндсэн хөрөнгийн сайжруулалт дансанд бүртгэхдээ харьцсан дансыг буруу сонгосныг бусад орлогоор бүртгэсэн	1	26,666.7			1	26,666.7	1	26,666.7				
Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг хойшлогдсон татварын өр буруу тусгасныг орлогын дэлгэрэнгүй тайлангийн бусад орлогоор бүртгэж	1	799,909.7			1	799,909.7	1	799,909.7				
ОНХСангаас орж ирсэн санхүүжилтийг зөрүүтэй олгосноос	1	20,000.0			1	20,000.0	1	20,000.0				

зарцуулсан зардлыг орлогын дэлгэрэнгүй тайланд тусгасан												
Дүн	5	1,441,297.5			5	1,441,297.5	5	1,441,297.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Техник /ковш/ түрээсийн орлого байгууллагын харилцахад орж ирсэн боловч гэрээ байгуулаагүй, машин техникийн ашиглах хугацаа, хариуцан хүлээж авсан, хүлээлгэн өгсөн акт үйлдсэн тэмдэглэл, дэмжих баримтгүй	1	3,186.8			1	3,186.8						
Байгууллагын бүх ажилчдад орон нутгийн нэмэгдэл нийт 33,492.7 мянган төгрөгийг олгосон	1	33,492.7	1	33,492.7								
Буруутай этгээдээр торгуулийн төлбөрийг төлүүлэхгүй байгууллагын хөрөнгөөр төлсөн	1	500.0	1	500.0								
Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэл дэх 38,860.2 мянган төгрөгийн 60квт дизель станц хөрөнгийг бусдад түрээсийн гэрээ байгуулан ашиглуулсан боловч биетээр оршин байхгүй, хөрөнгийг буцаан авахтай холбоотой шүүхийн байгууллагад хандан өмгөөлөгчийн төлбөрт 1,500.0 мянган төгрөг төлсөн	1	38,860.2			1	38,860.2						
Дүн	4	76,039.7	1	33,992.7	2	42,047.0	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

	Нийт зөрчил	Үүнээс
--	-------------	--------

Зөрчлийн товч утга			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллаг ад шилжүүлсэ н асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал тны тоо	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар												
Шилэн дансны 158 мэдээнээс 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 53,459.3 мянган төгрөгийн 2 гүйлгээ, зарлагын 42,293.2 мянган төгрөгийн зарлагын 5 гүйлгээг мэдээлээгүй	1	95,752.5			1	95,752.5						
Байгууллагын гэрчилгээ дээрх өмчийн дүн санхүүгийн тайлан дээрх өмчийн дүнгээс зөрүүтэй илэрхийлэгдсэн	1	413,843.9					1	413,843.9				
Дүн	1	537,596.4	-	-	1	95,752.5	1	413,843.9	-	-	-	-